



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/294
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

[Signature]

Ц.НАРАНЧИМЭГ



СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл

САГазрын дарга: Ц. Наранчимэг
Утас: 261663

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу

САГазрын захирал: С.Энхзаяа
Утас: 261663
Цахимхаяг:
enkhhappy@yahoo.com

Ахлах аудитор: Н.Батсайхан
Утас: 261885
Цахимхаяг:

Үндэсний Аудитын Газар
Засгийн газрын Үбайр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол улс
Цахим хуудас: www.mnao.mn

“Юнистар” АУДИТ ХХК
Захирал: ГЭНХМАА

2016 оны 2 дугаар сар

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Аудит хийсэн төсвийн
гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго,үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг түвшин
6. Дотоод хяналт
7. Шилэн дансны мэдээлэл
8. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дүгээр заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагааны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/289/СТА-ТШЗ / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагааны 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагааны 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дүгээр сарын 25-ны хугацаанд хийхээр төлөвлөн “Юнистар Аудит” ХХК-ийн аудитор М. Энхжаргал, чанарын хяналтын менежер Д. Сүхээ, аудиторын туслах Ц. Энхчимэг, Ц. Тунгалагнар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 01 дүгээр сарын 23-нд “Юнистар Аудит” ХХК-д ирүүлсэн.

“Юнистар Аудит” ХХК нь аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 23-наас 2017 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 02 дугаар сарын 25-нд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай хууль”/нэмэлт өөрчлөлт орсон/, “Төрийн албаны тухай хууль”/нэмэлт өөрчлөлт орсон/, “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль”/шинэчилсэн/, “Эрүүл мэндийн тухай хууль”, “Эм эмнэлэгийн хэрэгслийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Төрийн аудитын тухай хууль”, “Нийгмийн даатгалын тухай хууль”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Шилэн дансны тухай хууль”-иуд болон эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн яамны сайдын

Төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан

тушаал, Сангийн сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Танилцуулга

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 39 дүгээр зүйл, Монгол Улсын Сэтгэцийн Эрүүл Мэндийн хуулийн 7-р зүйлийн 3-р заалт, Эрүүл Мэндийн Сайдын 2006 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 331-р тушаалаар Эрүүл Мэндийн Яамны харьяа Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв шинээр зохион байгуулагдсан.

АЛСЫН ХАРАА- Бидний ирээдүй

Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжингүй орны түвшинд хүргэж, нийгмийн эрүүл мэндийн тэргүүлэх салбар болгоно. Монголын нийт хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг чанартай тэгш хүртээмжтэй үзүүлэн, анхан, хоёрдахь шатлалын тусламжийг мэргэжил арга зүйгээр хангахад оршино.

Үйл ажиллагааны стратегийн зорилтууд

Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллах, анхан болон хоёрдахь шатлалын тусламжийг мэргэжил арга зүйгээр хангах, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, сэтгэц нийгмийн нөхөн сэргээх гуравдахь шатлалын тусламж үйлчилгээг чанартай тэгш хүртээмжтэй хүргэх, Архидан согтуурах, мансуурах, тоглоомд донтох, стресст өртөх зэрэг сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх нийгэм орчны сөрөг хүчин зүйлсээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, Эрдэм шинжилгээ, статистик, тандалт судалгаа, мэдээллийн сүлжээ, гадаад харилцааг хөгжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төсөв санхүүгийн удирдлага зохион байгуулалт, нөөцийн хуваарилалтыг сайжруулах зэрэг зорилт тавин ажиллаж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллагын түүний үйл ажиллагааг урашигтай удирдлагаар хангах ажлын үрдүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагч байна. 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Төсвийн бусад байгууллагын дарга /захирал эрхлэгч/ тухайн байгууллагын төсвийн захирагч байна” гэж заасны дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захиралт төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны төсвийг Эрүүл мэндийн яамны төрийн сангаас олгож байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудитхийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан горим, сорил 28-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ЭМ-ийн сайдын 2010 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 138 тоот тушаалаар батлагдсан эрүүл мэндийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажилгаанд тохируулан мөрдөж байна. Тус газар нь Санхүүгийн тооцооллын АСОЛОУС-3.0 санхүүгийн програмаар санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлээ хөтөлж байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу тайлангаа бэлтгэсэн байна.

5. Материаллаг байдал:

Бид санхүүгийн тайланд материаллаг байдлыг авч үзэхдээ Төсвийн болон өөрийн орлогын хэмжээ байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлно гэж үзээд материаллаг түвшинг орлогын 1 хувиар буюу алдааг хүлээн зөвшөөрөх нийт хэмжээг 112.6 сая төгрөгөөр тооцоолов. /ТАБ-СТА-В-1/

6. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний

төвийндотоод хяналт эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянах явцад дотоод хяналт хэвийн байна.

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Эрүүл мэндийн яамны төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал зардалд 9,218.4 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 1,577.5 сая төгрөг, бусад орлого 4.8 сая төгрөг, үнэ төлбөргүй авсан орлого 8.4 сая төгрөг, өөрийн орлого 335.3 сая төгрөг, нийт 11,261.0 сая төгрөгийн орлого олжээ. Үүнээс урсгал зардалд 10,529.0 мянган төгрөгийг зарцуулж Сангийн яаманд 65.7 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

8. Шилэн дансны мэдээлэл

СЭМҮТ нь “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”, Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зарчмын дагуу 2016 онд 15,094.317,19 мян/төг-ийн 493 ширхэг мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудас болон Эрүүл мэнд, спортын яам, сангийн яамны цахим хаягаар улирал бүрийн хуулийн хугацаанд тайлан мэдээг илгээж ажилласан байна. Үүнд тендерт оролцсон нарийн мэдээлэлийн тухай 32 удаа, 5 саяаас дээш худалдан авалт /Тендерийн худалдан авалт/-ын тухай 213 удаа, Цалингийн зардлаас бусад 5 саяаас дээш зардлыг 48 удаа, 5 саяаас дээш орлогыг 46 удаа, Хөрөнгө зарцуулах эрхийн акт, гэрээ, тушаалыг 113 удаа, Бусад мэдээлэлийг 41 удаа тавьсан байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 дансанд эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд хяналтын болон нарийвчилсан горим, сорил 28-ийг гүйцэтгэв. Аудитын төлөвлөлтийн явцад уламжлалт болон хяналтын эрсдэлүүдийг тооцоход санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаж ажилласан байна.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, орлогууд, цалин хөлс болон түлш халаалт, гэрэл цахилгаан зэрэг дансандажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант онд үндсэн хөрөнгө 1,413.8 сая төгрөгөөр нэмэгдсэн. Энэ нь барилга байгууламж 17.3 сая төгрөг, тээврийн хэрэгсэл 58.0 сая төгрөг, тоног төхөөрөмж 788.9 сая төгрөг, тавилга 532.0 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө 7.0 сая төгрөг, програм хангамж 10.5 сая төгрөг болон нэмэгдсэн. Мөн 78.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 15-ны 277 тоот тогтоолоор акталсан байна.

Тайлант оны эхэнд нийт 32.0 сая төгрөгийн авлага буюу энэ нь сангийн яаманд төвлөрүүлсэн орлогоос авах тооцоо 29.1 сая төгрөг, Жи энд Эс ХХК-иас авах тооцоо 2.9 сая төгрөг байсан. Тус байгууллага нь өмнөх оны үлдэгдэл авлагаа барагдуулсан бөгөөд тайлант хугацааны эцэст нийт 4.6 сая төгрөгийн авлага үүссэн. Энэ нь Нийгмийн даатгалын байгууллагатай тооцох авлага 3.3 сая төгрөг, Сангийн яамнаас 1.3 сая төгрөгийн авлага үүссэн байна.

Тус байгууллага нь төсвийн гүйцэтгэлээр 9,558.6 сая төгрөгийн зардалтай ажилласан бөгөөд зардлын 61.7 хувь буюу 5,901.7 сая төгрөг нь цалингийн зардал эзэлж байна.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй байна.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Тайлант хугацаанд худалдан авсан 46.6 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийн шинжтэй зүйлсийг /хөлийн массажны аппарат 13.5 сая төгрөг, 7.6 сая төгрөгийн угаалгын машин, 4.6 сая төгрөг өвчтөнийн сандал, 12.4 сая төгрөг, уурын зуухны мотор 8.5 сая төгрөгийн ус цэвэршүүлэгч гэх мэт/ бараа материалын дансанд бүртгэн орлого болгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг дагаж мөрдөнө" гэсэн заалт болон УСНББОУС-12-ын Тодруулга 47-б.д "Бараа материалын нийт дансны үнэ болон тухайн байгууллагад тохирох ангилал тус бүрийн бараа материалын дансны үнэ", УСНББОУС-17 Тодорхойлолт 13-д "Үндсэн хөрөнгийн анги гэдэг нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг эсвэл ижил шинж чанараар нь ангилсан хөрөнгийн бүлэглэл бөгөөд түүнийг

Төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан

санхүүгийн тайлангийн тодруулгад нэг зүйл болгон илэрхийлдэг”, "УСНББОУС-1 94-д “ дэд ангилалд багтсан дэлгэрэнгүй мэдээлэл нь УСНББОУС –ын шаардлагаас болон хамрагдсан дүнгийн хэмжээ, шинж чанар, чиг үүргээс хамаарна, дэд ангиллын суурийг тогтооход 91-р зүйлд заасан хүчин зүйлийг ашиглана”, гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Бараа материалын үлдэгдэл нь өмнөх оноос 213,600.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөх, Үндсэн хөрөнгийн бүртгэлд УСНББОУС-д заагдсан үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн хандлагын дагуу үндсэн хөрөнгийн тодорхойлолт, хүлээн зөвшөөрөлт, хөрөнгийн ангилах тусгайлсан бодлогыг НББ-ийн бодлогын баримт бичигтээ тодорхойлж байгууллагад тууштай мөрдөж ажиллах тухай зөвлөмж өгсөн

2. Тус байгууллага нь төлбөрт эмчилгээ үзүүлсэний орлогоос 408.5 сая төгрөг олно гэж төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 335.3 сая төгрөгийн орлого олж, 73.2 сая төгрөг буюу 17,9 хувиар тасарсан байна. Энэ нь өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг өндөр төлөвлөснөөс болж төлөвлөгөө тасарсан бөгөөд Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, төсвийн орлогыг бодитой төлөвлөх тухай зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаар болсон. Нийгмийн хөгжлийг дагаад сэтгэцийн эмгэг өсдөг. 1992 оныг 2013 онтой харьцуулахад стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг 10 дахин, архинд донтох эмгэг 40 дахин нэмэгдсэн. Неврозын тасагт стрессийн шалтгаантай архаг ядаргаатай эмчлүүлэгчдээс гадна сэтгэл гутрал, айдас түгшүүр, солиорлын эхэн үеийн нойргүйтэл зэрэг сэтгэцийн эмгэгтэй хүмүүс их хэвтдэг болсон учраас Сэтгэцийн эрүүл мэндийн хуулийн дагуу төлбөргүй, төрөөс тусламж үйлчилгээг үнэгүй авч хэвтдэг хүмүүс нэмэгдсэн. Эрүүл хүүхдийн 25 ортой тасаг, анхны хэвтэлтийн 30 ортой тасаг нээгдэж ажилласнаар төлбөртэй тасгийн орны тоог бууруулах болсон.

3. Тус байгууллага нь Эрүүл мэндийн сайдын 2010 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 138 тоот тушаалаар батлагдсан эрүүл мэндийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажилгаанд тохируулан баримтлан ажиллаж байгаа ч УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон аудитын тухай хууль, дүрэм, журмын өөрчлөлт, Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоол хүчингүй болж, үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулахдаа УСНББОУС-17-г дагаж мөрдөх болсон өөрчлөлтийг тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь

Төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан

санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах" гэсэн заалтыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгсөн. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг дахин шинэчлэн батлахаар боловсруулалт хийж байна. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаар болсон.

12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Тайлант хугацаанд худалдан авсан 46.6 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийн шинжтэй зүйлсийг /хөлийн массажны аппарат 13.5 сая төгрөг, 7.6 сая төгрөгийн угаалгын машин, 4.6 сая төгрөг өвчтөнийн сандал, 12.4 сая төгрөг, уурын зуухны мотор 8.5 сая төгрөгийн ус цэвэршүүлэгч гэх мэт/ бараа материалын дансанд бүртгэн орлого болгосон байна. Энэ нь тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж ашиглагдах хугацаа дуусахаас өмнө эвдрэх магадлалтай хөрөнгийг бүртгэсэн бөгөөд үргүй зарцуулах эрсдэл үүсэхгүй. Учир нь эвдэрч гэмтээгүй, ашиглалтын шаардлага хангаж байгаа хөрөнгийг акталж, устгахгүй, эд хөрөнгийн тооллогонд хамруулж эд хариуцагч нартай тооцоо бодож хөрөнгөнд бүртгэлээр хяналт тавьдаг учир залруулаагүй үлдээсэн.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг дахин давтахгүй байхыг зөвлөв.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2015 оны санхүүгийн тайланд Юнистар Аудит ХХК-аас хийсэн аудитаар 4 зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлсэн байна.

17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт

Төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажилгүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан, менежементийн захидал, асуулгын бүртгэл, байгууллагын санхүүгийн тайлан болон судалгаа, саналын хуудсыг тус тус хавсаргав.



СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Тэргүүлэх ач холбогдол № 1

Тэргүүлэх ач холбогдол № 2

Асуудал 1

Бараа материалын талаар.....3

Асуудал 2

Өөрийн орлогын талаар.....5

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимд зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хяналт хийсэн бөгөөд оршин буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмжүүд маань дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ерөнхий захирал, ерөнхий нягтлан бодогч бусад албаны дарга нар болон санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Ажиглалт

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгө оруулалтаар хүлээн авсан 46.6 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийн шинжтэй зүйлсийг /хөлийн массажны аппарат 13.5 сая төгрөг, 7.6 сая төгрөгийн нугаалгын машин, 4.6 сая төгрөгөвтөнийн сандал, 12.4 сая төгрөг, уурын зуухны мотор 8.5 сая төгрөгийн нусцэвэршүүлэгч гэх мэт/ бараа материалын эд хогшил дансанд бүртгэн орлого болгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг дагаж мөрдөнө" гэсэн заалт болон УСНББОУС-12-ын Тодруулга 47-б.д "Бараа материалын нийт дансны үнэ болон тухайн байгууллагад тохирох ангилал тус бүрийн бараа материалын дансны үнэ", УСНББОУС-17 Тодорхойлолт 13-д "Үндсэн хөрөнгийн анги гэдэг нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг эсвэл ижил шинж чанараар нь ангилсан хөрөнгийн бүлэглэл бөгөөд түүнийг санхүүгийн тайлангийн тодруулгад нэг зүйл болгон илэрхийлдэг", "УСНББОУС-1 94-д " дэд ангилалд багтсан дэлгэрэнгүй мэдээлэл нь УСНББОУС –ын шаардлагаас болон хамрагдсан дүнгийн хэмжээ, шинж чанар, чиг үүргээс хамаарна, дэд ангиллын суурийг тогтооход 91-р зүйлд заасан хүчин зүйлийг ашиглана", гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Бараа материалын үлдэгдэл нь өмнөх оноос 213,600.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Эрсдэл

Хөрөнгөнд бүртгэлээр тавих дотоод хяналт хэрэгжихгүй бөгөөд хөрөнгийг үргүй зарцуулах эрсдэлтэй. Ил, Х, Үн, Т

Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлд УСНББОУС-д заагдсан үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн хандлагын дагуу үндсэн хөрөнгийн тодорхойлолт, хүлээн зөвшөөрөлт, хөрөнгийн ангилах тусгайлсан бодлогыг НББ-ийн бодлогын баримт бичигтээ тодорхойлж байгууллагад тууштай мөрдөж ажиллах
2. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэх

СЭМҮТ-ийн хариу

СЭМҮТ-ийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж ашиглагдах хугацаа дуусахаас өмнө эвдрэх магадлалтай хөрөнгийг үргүй зарцуулах эрсдэл үүсэхгүй. Учир нь эвдэрч гэмтээгүй, ашиглалтын шаардлага хангаж байгаа хөрөнгийг акталж, устгахгүй, эд хөрөнгийн тооллогонд хамруулж эд хариуцагч нартай тооцоо бодож хөрөнгөнд бүртгэлээр хяналт тавьдаг.

2016 онд бараа материалын үлдэгдэл 213 сая төгрөгөөр нэмэгдсэн. Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 165 сая төгрөгийн бараа материал, хандив тусламжаар 6.8 сая төгрөгийн мэргэжлийн ном, гарын авлага ирсэн нь бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн.

Асуудал 2: Орлогын талаар

Тэргүүлэхачхолбогдол №2

Ажиглалт

Тус байгууллага нь төлбөрт эмчилгээ үзүүлсэний орлогоос 408.5 сая төгрөг олно гэж төлөвлөсөн боловч 73.2 сая төгрөгөөр буюу 17,9 хувиар тасарсан байна. Энэ нь өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг өндөр төлөвлөснөөс болж төлөвлөгөө тасарсан бөгөөд Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэл

Орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүйгээс төсөвт орох орлогын хэмжээ буурах

Зөвлөмж

1. Төсвийн тухай хууль мөрдөж, төсвийн орлогыг бодитой төлөвлөх

СЭМҮТ-ийн хариу

Төлбөртэй эмчилгээ үзүүлснээс орох орлогын төлөвлөгөө 408,500 мянган төгрөгөөр төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 335,227 мянган төгрөгийг төрийн санд төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй. Учир нь Нийгмийн хөгжлийг дагаад сэтгэцийн эмгэг өсдөг. 1992 оныг 2013 онтой харьцуулахад стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг 10 дахин, архинд донтох эмгэг 40 дахин нэмэгдсэн. Неврозын тасагт стрессийн шалтгаантай архаг ядаргаатай эмчлүүлэгчдээс гадна сэтгэл гутрал, айдас түгшүүр, солиорлын эхэн үеийн нойргүйтэл зэрэг сэтгэцийн эмгэгтэй хүмүүс их хэвтдэг болсон учраас Сэтгэцийн эрүүл мэндийн хуулийн дагуу төлбөргүй, төрөөс тусламж үйлчилгээг үнэгүй авч хэвтдэг хүмүүс нэмэгдсэн. Эрүүл хүүхдийн 25 ортой тасаг, анхны хэвтэлтийн 30 ортой тасаг нээгдэж ажилласнаар төлбөртэй тасгийн орны тоог бууруулах болсон.

Ажиглалт

Тус байгууллага нь Эрүүл мэндийн сайдын 2010 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 138 тоот тушаалаар батлагдсан эрүүл мэндийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажилгаанд тохируулан ажиллаж байгаа ч УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон аудитын тухай хууль, дүрэм, журмын өөрчлөлт, Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоол хүчингүй болж, үндсэн хөрөнгийн элэгдлийг байгуулахдаа УСНББОУС-17-г дагаж мөрдөх болсон өөрчлөлтийг тусгаагүй байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

СЭМҮТ-ийн хариу

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг дахин шинэчлэн батлахаар боловсруулалт хийж байна. Энэхүү бодлогын баримт бичигт Үндсэн хөрөнгийн дансны үнэ, ашиглалтын хугацаа зэргийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын шийдвэр, СЭМҮТ-ийн Ерөнхий захирлын тушаалыг дагаж мөрдөнө гэж тусгасан. 2016 оны тайлант жилд Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын шийдвэрээр үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг НББ-д тусгаж ажилласан болно.

Төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ 2016 оны 12-р сарын 31-ний байдлаар
(Төгрөгөөр)

Балансын зүйл	Тэм	Эхний үлдэгдэл	Аудитлагдсан
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө		-	-
АВЛАГА		32,011,750.00	4,556,736.00
Бусад байгууллагаас авах авлага			-
бусад авлага		32,011,750.00	4,556,736.00
БАРАА МАТЕРИАЛ		682,243,890.97	895,844,427.97
Түүхий эд материал		116,898,289.75	101,850,328.96
Хангамжийн материал		565,345,601.22	793,994,099.01
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		714,255,640.97	900,401,163.97
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
ҮНДСЭН ХӨРӨНГӨ		9,592,065,171.65	10,137,891,485.29
Биет хөрөнгө		9,576,316,838.49	10,118,863,360.59
барилга байгууламж		10,748,437,968.76	10,765,753,968.76
Хуримтлагдсан элэгдэл		(4,145,182,010.34)	(4,340,935,657.62)
авто тээврийн хэрэгсэл		111,986,000.00	169,986,000.00
Хуримтлагдсан элэгдэл		(56,923,500.06)	(76,909,611.18)
машин тоног төхөөрөмж		3,239,647,401.60	3,981,081,096.80
Хуримтлагдсан элэгдэл		(936,235,066.66)	(1,382,167,960.48)
Тавилга, аж ахуйн эд хогшил		838,240,995.36	1,339,879,030.46
Хуримтлагдсан элэгдэл		(235,559,331.79)	(353,702,352.46)
Зам гүүрийн барилга байгууламж		7,119,599.99	7,119,599.99
Хуримтлагдсан элэгдэл		(1,803,036.83)	(2,244,596.87)
Бусад үндсэн хөрөнгө		18,667,143.01	24,645,688.00
Хуримтлагдсан элэгдэл		(12,079,324.55)	(13,641,844.81)
Дуусаагүй барилга байгууламж			-
Биет бус хөрөнгө		15,748,333.16	19,028,124.70
Программ хангамж		26,235,000.00	36,695,000.00
Хуримтлагдсан элэгдэл		(10,486,666.84)	(17,666,875.30)
НИЙТ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		9,592,065,171.65	10,137,891,485.29
НИЙТ ХӨРӨНГӨ		10,306,320,812.62	11,038,292,649.26
ӨР ТӨЛБӨР			
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат зээл			
Өглөг		-	-
ажиллагсадтай холбогдсон тооцоо			-
бусад өглөг			-
Богино хугацаат өр төлбөрийн дүн		-	-
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР			
Урт хугацаат зээл			
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		-	-
ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		-	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧ			
Засгийн газрын хувь оролцоо		6,989,077,755.29	6,989,077,755.29
өмнөх үеийн үр дүн		685,364,278.03	1,100,211,594.46
Тайлант үеийн үр дүн		414,847,316.43	731,971,836.64
дахин үнэлгээний зөрүү		2,217,031,462.87	2,217,031,462.87
ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН		10,306,320,812.62	11,038,292,649.26
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		10,306,320,812.62	11,038,292,649.26

Төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ /төгрөгөөр/

	Тэм	Өмнөх он	Аудитлагдсан
ТАТААС БА САНХҮҮЖҮҮЛЭЛТИЙН ОРЛОГО		8,922,227,573.52	9,363,971,950.00
Улсын төсвөөс		8,837,811,830.00	9,218,424,000.00
урсгал		8,837,811,830.00	9,218,424,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болс		34,310,350.00	116,456,500.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		50,105,393.52	29,091,450.00
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО		453,708,660.47	340,148,812.00
Үндсэн үйл ажиллагааны орлого		324,927,086.00	335,277,026.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		128,781,574.47	4,871,786.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН 1		9,375,936,233.99	9,704,120,762.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ			
АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ		6,623,140,975.75	6,569,844,381.46
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		5,968,475,684.11	5,912,637,254.05
цалин		5,550,767,534.11	5,465,283,312.05
цалингийн тусгай нэмэгдлүүд		417,708,150.00	447,353,942.00
Нийгмийн даатгал		654,665,291.64	657,207,127.41
тэтгэвэр болон тэтгэвэрийн шимтгэл		654,665,291.64	657,207,127.41
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ		2,743,592,468.24	3,132,726,380.54
Тогтмол зардал		782,633,398.00	763,051,098.00
гэрэл цахилгаан		136,954,348.00	156,036,998.00
түлш халаалтын зардал		623,053,000.00	596,304,100.00
цэвэр бохир усны зардал		22,626,050.00	6,550,000.00
байрны түрээсийн зардал			4,160,000.00
Үйл ажиллагааны зардал		1,357,249,900.00	1,493,081,300.00
Хоол		738,757,000.00	735,551,037.91
Эм		618,492,900.00	757,530,262.09
Бусад бараа үйлчилгээний зардал		603,709,170.24	876,593,982.54
бичиг хэргийн зардал		24,628,400.00	24,974,573.00
Тээвэр шатахууны зардал		28,696,400.00	29,309,600.00
Шуудан холбооны зардал		7,747,320.00	7,465,200.00
Дотоод томилолтын зардал		3,697,100.00	20,866,800.00
Ном хэвлэлийн зардал		387,500.00	-
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс		12,696,050.00	20,324,200.00
зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал		48,835,000.00	56,119,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,үйлчилгээний төлбөр		12,875,570.30	38,788,404.00
урсгал засварын зардал		70,696,743.52	116,082,168.00
Хог хаягдал устгах цэвэрлэх		93,351,920.00	74,065,200.00
төвлөрүүлэх		82,676,516.42	65,699,828.54
хөтөлбөр арга хэмжээний зардал		142,549,850.00	165,746,109.00
нэг удаагийн тэтгэмж урамшуулал		28,050,800.00	257,152,400.00
Шагнал урамшуулал		46,820,000.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН		9,366,733,443.99	9,702,570,762.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		9,202,790.00	1,550,000.00
биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал		9,202,790.00	1,550,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН		9,202,790.00	1,550,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		(9,202,790.00)	(1,550,000.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-

Төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

/төгрөгөөр/

	Засгийн газрын оруулсан капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний сан	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцоо
	MNT	MNT	MNT	MNT
2015 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	6,989,077,755.29	2,217,031,462.87	1,100,211,594.46	10,306,320,812.62
Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,989,077,755.29	2,217,031,462.87	1,100,211,594.46	10,306,320,812.62
Тайлант хугацаанд нэмэгдсэн				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Бэлэг, хандиваар авсан хөрөнгө				-
Тайлант үеийн үр дүн			731,971,836.64	731,971,836.64
2016 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	6,989,077,755.29	2,217,031,462.87	1,832,183,431.10	11,038,292,649.26

Төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	9,626,924,000.00	9,558,572,812.00	68,351,188.00	99.29
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	9,626,924,000.00	9,558,572,812.00	68,351,188.00	99.29
Бараа үйлчилгээний зардал	9,626,924,000.00	9,558,572,812.00	68,351,188.00	99.29
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	5,916,431,000.00	5,901,736,614.05	14,694,385.95	99.75
Үндсэн цалин	4,585,875,000.00	5,454,382,672.05	(868,507,672.05)	118.94
Бусад нэмэгдлүүд	1,330,556,000.00	447,353,942.00	883,202,058.00	33.62
Ажил олгогчоос төлөх НДШ	709,971,700.00	657,207,127.41	52,764,572.59	92.57
Бараа үйлчилгээний зардал	3,000,521,300.00	2,999,629,070.54	892,229.46	99.97
Тогтмол зардал	814,342,800.00	758,891,098.00	55,451,702.00	93.19
Гэрэл цахилгаан	167,281,800.00	156,036,998.00	11,244,802.00	93.28
Түлш халаалт	637,700,000.00	596,304,100.00	41,395,900.00	93.51
Цэвэр, бохир ус	9,361,000.00	6,550,000.00	2,811,000.00	69.97
Бараа үйлчилгээний бусад зардал	2,186,178,500.00	2,240,737,972.54	(54,559,472.54)	102.50
Бичиг хэрэг	5,979,300.00	5,979,300.00	-	100.00
Тээвэр, шатахуун	28,470,600.00	28,470,600.00	-	100.00
Шуудан холбоо	6,958,600.00	7,271,600.00	(313,000.00)	104.50
Дотоод албан томилолт	2,978,000.00	2,291,800.00	686,200.00	76.96
Хоол	733,851,500.00	730,751,037.91	3,100,462.09	99.58
Хог хаягдал устгах цэвэрлэх	74,665,200.00	74,065,200.00	600,000.00	-
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	14,505,300.00	14,877,200.00	(371,900.00)	102.56
Нормын хувцас зөөлөн эдлэл	56,120,000.00	56,119,500.00	500.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зар,	42,396,500.00	40,338,404.00	2,058,096.00	95.15
Бараа үйлчилгээний бусад зардал	125,912,600.00	125,841,123.00	71,477.00	99.94
Урсгал засвар			-	
Эд хогшил худалдан авах	82,758,700.00	78,059,477.00	4,699,223.00	94.32
Эм бэлдмэл эмнэлэгийн хэрэгсэл	754,429,800.00	757,530,262.09	(3,100,462.09)	100.41
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	257,152,400.00	257,152,400.00	-	
Засгийн газар хоорондын шилжүүлэг		61,990,068.54	(61,990,068.54)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,626,924,000.00	9,558,572,812.00	68,351,188.00	99.29
төсвөөс <i>ᠯᠠᠭᠠᠨ ᠠᠨᠠᠭᠠᠨ</i>	9,218,424,000.00	9,218,424,000.00	-	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	408,500,000.00	335,277,026.00	73,222,974.00	
Бусад орлого		4,871,786.00	(4,871,786.00)	
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
АЖИЛЛАГСАД БҮГД	497.00	497.00	-	100.00
Удирдах ажилтан	11.00	11.00	-	100.00
гүйцэтгэх ажилтан	224.00	224.00	-	100.00
үйлчлэх ажилтан	262.00	262.00	-	100.00
	-	-		

Бэлтгэсэн: Аудитор

М.Энхжаргал

Огноо:

2017 оны 02-р сарын 10-ны өдөр

**МОНГОЛЫН ТЕАТРЫН
АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал
C01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	70,433,859.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	70,433,859.73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	
C07	Тайлант үеийн үр дүн	
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	70,433,859.73
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	70,433,859.73
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	70,433,859.73
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	
D08	Тайлант үеийн үр дүн	
D09	6 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	70,433,859.73

Бэлтгэсэн аудитор:

Б.Бямбасүрэн

Анхан шатны хяналт хийсэн менежер:

Б.Бурмаа

Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
720,719,933.00	37,214,428.27		828,368,221.00
			0.00
720,719,933.00	37,214,428.27	0.00	828,368,221.00
			0.00
			0.00
			0.00
			0.00
720,719,933.00	37,214,428.27	0.00	828,368,221.00
720,719,933.00	37,214,428.27	0.00	
			0.00
720,719,933.00	37,214,428.27	0.00	828,368,221.00
			0.00
			0.00
			0.00
			0.00
	-15,609,252.54		-15,609,252.54
720,719,933.00	21,605,175.73	0.00	812,758,968.46